



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 98

Улаанбаатар хот

«Барилга байгууламжуудыг нийслэлийн
өмчид бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт улсын болон дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр баригдаж ашиглалтад орсон, нийт 7,154,223,825.29 (долоон тэрбум нэг зуун тавин дөрвөн сая хоёр зуун хорин гурван мянга найман зуун хорин таван төгрөг хорин есөн мөнгө) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад дурдсан 5 барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100800

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн
᠑᠘ дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	105 дугаар сургуулийн спорт заалны өргөтгөлийн барилга	Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хороо, Хувьсгалчдын зам гудамж, наран-1-11	2021	980,378,460.00	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
2	314 дүгээр цэцэрлэгийн барилга	Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хороо, Хонхорын 2-1	2023	1,936,694,359.00	
3	Хорооны Иргэдийн хөгжлийн төвийн барилга	Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо, биокомбинат	2022	1,944,195,698.00	
4	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 20 дугаар хорооны иргэдэд үйлчлэх байр	Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо Чингисийн өргөн чөлөө гудамж 94Б байр 1 давхар 1 тоот	2022	1,191,400,000.00	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт
5	65 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга	Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо 19-р хороолол, 52 дугаар сургуулийн баруун талд	2021	1,101,555,308.29	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл
Нийт бүртгэх барилга байгууламжийн дүн				7,154,223,825.29	